

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ  
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭГЧ:

Н.Норовсамбуу

## Агуулга

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хоёр. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

- 2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал
- 2.2 Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдал
- 2.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд
- 2.4 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Гурав. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судалсан нь

Тав. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

- 5.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 5.2 Нийгэмд үзүүлэх үр нөлөө
- 5.3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- 5.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
  - а. Холбогдох хүснэгтүүд
- 5.5 Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх

Зургаа. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судалсан байдал

Долоо. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Найм. Дүгнэлт, Зөвлөмж

**Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай  
хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг  
урьдчилан тандан судалсан судалгааны тайлан**

**НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох асуудалд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан доорх тандан судалгааг хийв.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх талаар судалж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.<sup>2</sup>

Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.<sup>3</sup>

Түүнчлэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-т нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн болон давж заалдах шатны шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” Арван хоёрдугаар бүлгээр гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байна.

Гэвч уг бүлэг нь зөвхөн гэрлэлт цуцлуулах тухай болон түүнтэй холбоотой хүүхдийн асрамж, тэтгэлэг гаргуулах гэх мэт нэхэмжлэлийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах журмаас бүрддэг буюу бусад гэр бүлийн

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721145671>

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140721217671>

холбогдолтой хэргийн төрлийг хамруулаагүй бөгөөд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зохицуулалт дутагдалтай байна.

Тодруулбал:

1/ИХШХШТХ-ийн 127 дугаар зүйлийн 127.1-д зааснаар гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар гарсан маргааныг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно. Энэ нь гэрлэлт цуцлахад насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх, хүүхдийн тэтгэлгийг тогтоох асуудлыг нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамааран шүүгч заавал хамтад нь шийдэх үүрэг болгосон зохицуулалт биш байна.

Иймээс шүүхийн практикт талуудаас нэхэмжлэл гаргаагүй гэх үндэслэлээр хүүхдийн тэтгэлгийг тогтоохгүйгээр гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэр гарч байна.

2/ИХШХШТХ-ийн 125 дугаар зүйлийн 125.1-д зааснаар гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ. Гэтэл тус бүлэгт заасан онцлог зохицуулалт нь нэхэмжлэл гаргах шүүхийн харьяалал, зохигч шүүх хуралдаанд ирэх, урьдчилсан арга хэмжээ болон ердийн журмаар хянан шийдвэрлэх явцад эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авч болох талаар юм.

Харин хэрхэн ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авах нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

3/ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4-т “Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.” гэж заасан. Гэтэл эвлэрэх боломжгүй бусад шаардлагатай тохиолдлыг хуульчлах шаардлага бий болсон.

Тухайлбал, шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2017 онд шийдвэрлэсэн гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэж,<sup>4</sup> гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан үзэхэд, гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон 1 буюу 2 хувь, архидалт 6 буюу 12 хувь, тусдаа амьдарч байгаа 4 буюу 8 хувь, гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлж байжээ.

4/Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн диспозитив зарчим хэрэгжихээс гадна хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах үүднээс fact finding буюу шүүгч өөрийн санаачилгаар нотлох ажиллагаа явуулах, гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулах зарчим одоогийн ИХШХШТХ-д байхгүй байна.

---

<sup>4</sup> С.Сүхбаатар, Б.Энх-Амгалан, Х.Санчир, Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть, 2023 он, 134-135 дахь тал.

5/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “гэр бүлийн холбогдолтой хэрэг”, “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан” гэх мэт өөр өөр нэр томъёог заасан байдаг төдийгүй зарим гэр бүлийн хэрэг болох хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, сэргээх, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг гэж тодорхойлсон.

Иймд гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлох, гэр бүлийн хэргийг тодорхойлох, түүнд тохирсон онцлог зохицуулалтыг бий болгох, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах үүднээс тухайн харилцааг нарийвчлан судлах шаардлагатай байна.

## ХОЁР. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

### 2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>5</sup> Арван зургадугаар зүйлийн 11-д "улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>6</sup> Арван есдүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт "Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ." гэж заасан.<sup>7</sup>

"Хүний эрхийн түгээмэл тунхаглал"<sup>8</sup>-ын Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Мөн гэрлэгчид гэрлэхдээ, гэрлэснийхээ дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй" гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, гэр бүл бол нийгмийн үндсэн нэгж бөгөөд төрөөр хамгаалуулах эрхтэй байдаг тул төрөөр хамгаалуулах, гэр бүлийн дотор хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг удирдлага болгодог буюу гэр бүлийн хэргийг шүүх хянан шийдвэрлэхэд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гэр бүлийн маргааныг эвийн журмаар шийдвэрлэх зохицуулалт, систем шаардлагатай болдог харилцаа болно.

Учир нь гэр бүлийн эрх зүйн харилцаа нь хувийн эрх зүйн харилцааны нэг боловч арилжааны шинжтэй бусад хувийн эрх зүйн харилцаанаас ялгагдах дээрх онцлогтоо тохирсон гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх зохицуулалттай байхыг шаардана.

Иймд уг судалгаагаар гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хөндөх болно.

<sup>5</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Зорилт 2.3.

<sup>8</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан.

## 2.2 Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдал

**Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ бусад асуудлыг цогцоор нь шийдвэрлэх тухайд:**

“Гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар гарсан маргааныг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно.”

*/ИХШХШтХ-ийн 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг/*

2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судлахад, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдэлгүй шүүх шийдвэрээ гаргасан байна.<sup>9</sup>

Гэтэл 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судлахад хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна.

Энэ нь 2017 оныхоос гэрлэлт цуцлахдаа хүүхдийн тэтгэлэг нэхэмжлээгүй ч зөвхөн цуцалсан шийдвэрийн хувь 20-оос 10 болж буурсан байна.<sup>10</sup>

Тухайлбал, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/ШШ2023/04812 дугаар шийдвэрээр гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэгч нэхэмжлэлдээ хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар тусгаагүй гэх үндэслэлээр шүүх хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй орхисон байна.<sup>11</sup>

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д “Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” Гэж, мөн зүйлийн 14.7-д “Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.” гэж тус тус заасан.

Үүний дагуу shuukh.mn-ээс гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэсэн 10 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн судаллаа.

<sup>9</sup> Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

<sup>10</sup> Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

<sup>11</sup> Shuukh.mn

Д/д	Шүүхийн нэр	Хүүхдийн асрамж тогтоосон байдал, үндэслэл		Хүүхэдтэй уулзах тусгай журам тогтоосон эсэх	Шийдвэрийн дугаар, холбоос
		Нэхэмжлэлийн шаардлага	Асрамжийн тогтоосон үндэслэл		
1.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	Гэрлэлт цуцалж, хүүхдийн асрамж тогтоолгох тухай	Асрамжийн талаар маргасан. ГБТХ-ийн 14.7-д заасан хүүхдийн саналыг авсан, хүүхдийн нас, хэний асрамжид байгаа, хүүхэд хүмүүжүүлэхэд дутагдалтай асуудал тогтоогдохгүй байгаа зэргийг харгалзан эхийн асрамжид үлдээсэн.	-	136/ШШ2022/00004
2.	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж болон тэтгэлэг тогтоолгох тухай	Асрамжийн талаар маргасан. ГБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.7-т зааснаар хүүхдүүдийн саналыг асууж, саналын дагуу ГБТХ-ийн 14.6-д зааснаар асрамжийг тогтоосон.	-	<u>183/ШШ2021/02793</u>
3.	Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгон, 70,200 төгрөг гаргуулах тухай	Асрамжийн талаар маргаагүй. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тул эхийн асрамжид хүүхдүүдийг үлдээн шийдвэрлэсэн.	-	<u>184/ШШ2021//00161</u>
4.	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоолгох тухай үндсэн нэхэмжлэлтэй, хүүхдүүдээ өөрийн асрамжид үлдээх, тэтгэлэг гаргуулах, хүүхдүүдийн сургалтын төлбөрийн 50 хувь болох 11,500,000 төгрөгийг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлтэй	Асрамжийн талаар маргасан. ГБТХ-ийн 14.6-д зааснаар Бага насны хүүхдүүд ( охин 10 настай, хүү 6 настай), бие биедээ эзэнэгшин дассан байдал эх нь байнгын ажлын байр зэргийг харгалзан үзсэн.	-	<u>181/ШШ2022/00680</u>
5.		Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоолгох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ногдох хэсгийг гаргуулах тухай	Асрамжийн талаар маргасан. Хүүхдийн санал, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, бага насны онцлог байдал зэргийг харгалзан үзэж, хамтад нь эхийн асрамжинд үлдээсэн.	-	<u>182/ШШ2023/01789</u>

6.	Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулах тухай	Асрамжийн талаар маргаангүй.  Эцэг хүүхдийн асрамжийг эхэд нь үлдээхийг зөвшөөрсөн тул эхэд асрамжийг үлдээн шийдвэрлэсэн. Тэтгэлэг гаргуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдсан.	-	<a href="#">183/ШШ2023/02392</a>
7.	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоолгох тухай Нэхэмжлэлийг нөхөр гаргасан.	Асрамжийн талаар маргаагүй.  Нөхөр нэхэмжлэл гаргахдаа асрамжийг эхэд үлдээхээр дурдсаныг эх зөвшөөрсөн тул хүүхдийг эхийн асрамжид үлдээн шийдвэрлэсэн.  ИХШХШТХ-ийн 126.4, 127.1, 132.5-д зааснаар гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хамт хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын өмчлөлийн эд хөрөнгийн талаар тодруулан, эдгээр асуудлыг хамтатган, нэг мөр шийдвэрлэхийг үндэслэх хэсэгтээ дурдаж, тогтоох хэсэгтээ зохигчдын тайлбарын дагуу гэрлэлт цуцалж асрамж тогтоосон.	-	<a href="#">182/ШШ2024/02466</a>
8.	Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж болон тэтгэлэг тогтоолгох, хамтран өмчлөн дундын хөрөнгөөс оногдох хэсгийг гаргуулах тухай	Асрамжийн талаар маргаагүй.  Асрамжийн талаар харилцан тохиролцсож, эхийн асрамжид үлдээсэн. Тэтгэлэг тогтоосон.	-	<a href="#">102/ШШ2024/02862</a>
9.	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Гэрлэлт цуцлуулах тухай үндсэн нэхэмжлэлтэй, Хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох сөрөг нэхэмжлэлтэй Нэхэмжлэлийг эхнэр гаргасан БНСУ-ын иргэн/	Асрамжийн талаар маргаагүй.  Асрамжийг эцэгт нь үлдээж, эхээр тэтгэлэг төлүүлэхээр шийдвэрлэсэн  Эцэг хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох сөрөг нэхэмжлэл гаргасныг эх зөвшөөрсөн тул хүүхдийг эцгийн асрамжид үлдээн шийдвэрлэсэн.	-	<a href="#">191/ШШ2025/02699</a>
10.	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Гэрлэлт цуцлуулах тухай	Зохигчдын хэн аль нь дундын өмчлөлийн маргаан байхгүй талаар мэдүүлсэн ба хүүхэдтэй боловч хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэл гаргаагүй тул тэдний шаардсан хэмжээнд хэргийг шийдвэрлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2-т нийцнэ гэж үндэслэх хэсэгтээ дүгнэсэн.	-	<a href="#">192/ШШ2025/00777</a>

Эндээс үзэхэд, гэрлэлт цуцлахад хүүхдийн асрамж, хүүхдийн тэтгэлэг тогтоох, хүүхэдтэй уулзах уулзалт тогтоох асуудлыг нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамааран заавал шийдэх зохицуулалт байхгүй, мөн шүүхийн практикт эдгээр

асуудлыг гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй заавал хамтад нь шийдвэрлэхгүй байна.

Хэрэв асрамжийн талаар маргасан бол хүүхдийн санал, хүүхдийг хүмүүжүүлэхэд дутагдалтай тал илрэхгүй гэж үзвэл хүүхдийг эхийн асрамжид үлдээх хандлагатай, зарим тохиолдолд зөвхөн хүүхдийн саналыг авч асрамжийг шийдсэн байна.

Мөн нэг хэрэгт зөвхөн гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан тул хүүхдийн асрамж, тэтгэлгийг шийдээгүй байна. Түүнчлэн нэг хэрэгт тэтгэлэг гаргуулах нэхэмжлэл гаргаагүй тул тэтгэлэг гаргуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдаж, гэрлэлтийг цуцалсан.

Түүнчлэн маргаагүй бол хүүхдийн саналыг авахгүй, эцэг, эхийн саналыг харгалзсан байдал ажиглагдаж байна.

Гэр бүлийн тухай хуулийн 14.6-д “Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” гэж заасны хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан үзэхэд шаардлагатай байдлыг шүүх маргаантай байгаа бүх тохиолдолд заавал тогтоодог байх шаардлагатай байна.

Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.” гэж заасны дагуу шүүгч өөрөө асуухаас илүү мэргэжлийн, хүүхэдтэй харилцаж, саналыг нь авахад суралцсан этгээдээр гүйцэтгүүлэх шаардлага байна.

Мөн тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийг хүүхэдтэйгээ уулзах уулзалтыг тогтоож шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байгааг анхаарах шаардлагатай болжээ.

### **Шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлалын талаар:**

ИХШХШТХ-ийн 125 дугаар зүйлийн 125.1-д зааснаар гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ. Гэтэл тус бүлэгт заасан онцлог зохицуулалт нь нэхэмжлэл гаргах шүүхийн харьяалал, зохигч шүүх хуралдаанд ирэх, урьдчилсан арга хэмжээ болон ердийн журмаар хянан шийдвэрлэх явцад эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авч болох талаар юм.

Харин ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд хэрхэн эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авах нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна. Гэтэл ийнхүү гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ нь шүүхийн шатанд бүрэлдээгүй байна.

Монгол Улсын хувьд, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар шүүхээс өнмө урьдчилсан арга хэмжээ болох эвлэрүүлэн зуучлал гэр бүлийн хэрэгт байдаг.

Түүврийн аргаар Shuukh.mn хуудаснаас гэрлэлт цуцлалттай холбоотой 5 хэргийг түүж судлахад дараах дүр зураг ажиглагдаж байна. Үүнд:

Гэрлэлт цуцлах шалтгаан гэрлэгчид тусдаа амьдарсны улмаас гэрлэлтээ цуцлах болсон. Гэрлэлт цуцлах асуудлаар шүүхийн Эвлэрүүлэн зуучлагчид хандаж байсан боловч эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон байна. Нотлох баримт хэргийн оролцогчид өөрсдөө нотлох баримтаар тайлбар, гэрлэлтийн лавлагаа зэргийг гаргасан. Шүүхээс нотлох баримт гаргаагүй байна.<sup>12</sup>

Гэрлэлт цуцлах шалтгаан зан харьцааны хувьд таарч тохирохгүй нөхрийн архи уудгаас болж тусдаа амьдарснаар салах болсон. Нотлох баримтаар талуудын өөрсдийн гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, зохигчийн тайлбар, хүүгийн гэрчилгээний хуулбар зэрэг материал авагдсан бөгөөд шүүхээс нотлох баримт цуглуулаагүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч гэрлэгчид эвлэрээгүй байна.<sup>13</sup>

Зан харилцааны таагүй байдлаас тус тусын амьдралтай болсон. Нотлох баримтаар зохигчдын гаргасан гэрлэлтийн гэрчилгээ, хүүхдийн гэрчилгээ, тайлбар зэрэг авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлалын арга хэмжээ амжилтгүй эвлэрээгүй.<sup>14</sup>

Хариуцагч өөр хүнтэй хамтран амьдрах болсон учир салах болсон байна. Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болсон эвлэрээгүй. Талууд гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар нотлох баримтаар гаргаж өгсөн. Шүүхээс нотлох баримт цуглуулаагүй.<sup>15</sup>

Тусдаа амьдарсны улмаас гэрлэлт цуцлах шалтгаан болсон. Эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон. Нотлох баримтаар гэрлэлт бүртгэлийн лавлагаа, тайлбар авагдсан. Шүүхээс баримт цуглуулаагүй.<sup>16</sup>

Эдгээр кэйсээс харахад, шүүхээс өмнөх шатны эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болж, шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахад шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлал хийгдээгүй байна.

Гэрлэлт цуцлах хэргийн тухайд, 2020 онд 3015 хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй буюу 353-т нь буюу 12 хувьд нь л амжилттай эвлэрсэн буюу гэрлэлт цуцлуулахаа болихоор шийдсэн байна. 2021 онд 3861 гэрлэлт цуцлах хэргийг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 88 хувьд нь амжилтгүй

---

<sup>12</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2020 оны 12 сарын 30 өдөр, дугаар 148/шш 2021/00005.

<sup>13</sup> Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2019 оны 12 сарын 25 өдөр, Дугаар 142 ШШ2020 00019.

<sup>14</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017 оны 12 сарын 13 өдөр, Дугаар 648.

<sup>15</sup> Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2016 оны 12 сарын 27 өдөр, дугаар 102 шш 2017 00041.

<sup>16</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, 2020 оны 12 сарын 30 өдөр, Дугаар 148 ШШ2021 00005.

эвлэрээгүй буюу гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлуулахаар болсон буюу дийлэнх тохиолдолд шүүхийн өмнөх шатны эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болж байна.

Иймд шүүхийн өмнөх эвлэрүүлэн зуучлалд зөвхөн хүчирхийллийн шалтгаанаас гадна тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн бол эвлэрүүлэн зуучлалд заавал хамрагдахыг шаардахаа болих шаардлагатайг энэхүү судалгаа харуулж байна.

### **Эвлэрүүлэн зуучлал шаардлагагүй тохиолдлын тухайд:**

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4-т “Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.” гэж заасан. Гэтэл эвлэрэх боломжгүй бусад шаардлагатай тохиолдлыг хуульчлах шаардлага бий болсон.

Тухайлбал, шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2017 онд шийдвэрлэсэн гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэж,<sup>17</sup> гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан үзэхэд, гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон 1 буюу 2 хувь, архидалт 6 буюу 12 хувь, тусдаа амьдарч байгаа 4 буюу 8 хувь, гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2 хувийг тус тус эзэлж байжээ.

Түүврийн аргаар Shuukh.mn хуудаснаас гэрлэлт цуцлалттай холбоотой 5 хэргийг түүж судлахад дараах дүр зураг ажиглагдаж байна. Үүнд:

Гэрлэлт цуцлах шалтгаан гэрлэгчид тусдаа амьдарсны улмаас гэрлэлтээ цуцлах болсон. Гэрлэлт цуцлах асуудлаар шүүхийн Эвлэрүүлэн зуучлагчид хандаж байсан боловч эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон байна.<sup>18</sup>

Гэрлэлт цуцлах шалтгаан зан харьцааны хувьд таарч тохирохгүй нөхрийн архи уудгаас болж тусдаа амьдарснаар салах болсон. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан боловч гэрлэгчид эвлэрээгүй байна.<sup>19</sup>

Зан харилцааны таагүй байдлаас тус тусын амьдралтай болсон. Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлалын арга хэмжээ амжилтгүй эвлэрээгүй.<sup>20</sup>

Хариуцагч өөр хүнтэй хамтран амьдрах болсон учир салах болсон байна. Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болсон эвлэрээгүй.<sup>21</sup>

---

<sup>17</sup> С.Сүхбаатар, Б.Энх-Амгалан, Х.Санчир, Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть, 2023 он, 134-135 дахь тал.

<sup>18</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2020 оны 12 сарын 30 өдөр, дугаар 148/шш 2021/00005.

<sup>19</sup> Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2019 оны 12 сарын 25 өдөр, Дугаар 142 ШШ2020 00019.

<sup>20</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017 оны 12 сарын 13 өдөр, Дугаар 648.

<sup>21</sup> Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2016 оны 12 сарын 27 өдөр, дугаар 102 шш 2017 00041.

Тусдаа амьдарсны улмаас гэрлэлт цуцлах шалтгаан болсон. Эвлэрлийн ажиллагаа амжилтгүй болсон.<sup>22</sup>

Эдгээр 5 кэйс бүрд тусдаа амьдрах болсон гэрлэгчид эврэлүүлэх арга хэмжээг заавал авсан боловч амжилтгүй болсон байна.

### **Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нөхцөл байдлыг тал бүрээс нь шинжлэн судлах тухайд:**

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн диспозитив зарчим хэрэгжихээс гадна хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах үүднээс fact finding буюу шүүгч өөрийн санаачилгаар нотлох ажиллагаа явуулах, гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулах зарчим одоогийн ИХШХШТХ-д байхгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасныг удирдлага болгон Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсантай холбогдуулан гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэр бүл, хүүхдийг хамгаалах үүднээс ердийн журмаас гадна онцлог, ач холбогдол бүхий зохицуулалтыг бий болгох шаардлагатай болсныг дээрх нөхцөл байдал илтгэж байна.

### **2.3 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд**

Шүүхээс гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журам боловсронгуй бус байгаагийн үр дагавар нь ихэвчлэн хэнд нөлөөлж байгааг харгалзан энэ хэсэгт эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тогтооё.

Монгол Улсад гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч нөхцөл байдлыг тал бүрээс нь судлах, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх, шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах зохицуулалт, эвлэрүүлэн зуучлалаар заавал орохгүй байх тохиолдлыг хуульчлах шаардлага үүссэн тул эдгээрийг орхигдуулснаас зарим сөрөг үр дагавруудыг бий болгож байна.

Хүснэгт 1

<b>№</b>	<b>Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг</b>	<b>Нөлөөлж буй хэлбэр</b>
1	Гэр бүл	Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхэд асуудлыг цогцоор нь шийдвэрлэж чадахгүйгээс гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсны дараа хүүхдийн тэтгэлэг тогтоогоогүй байх, хүүхэдтэйгээ амьдрах болсон эцэг, эсхүл эх орлогогүй, хэрхэн хүүхдийг цаашид асрах баталгаагүй, тусдаа амьдрах болсон эцэг, эсхүл эх хүүхэдтэйгээ уулзахгүй байх, эсхүл уулзуулахгүй байх зэргээр тухайн гэр бүлд хүндрэл бэрхшээл, үл ойлголцол, маргаантай асуудлууд үлддэг.

<sup>22</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, 2020 оны 12 сарын 30 өдөр, Дугаар 148 ШШ2021 00005.

2	Төр	Гэрлэлт цуцлалт ихсэж байна.
3	Хүүхэд	Хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчмын илрэл болсон шүүгч нөхцөл байдлыг тал бүрээс шинжлэн судлуулах тогтолцоо байхгүйгээс хүүхдэд ээлгүй шийдвэр гарах магадлалтай.
4	Олон нийт	Гэрлэлт цуцлалт нь өндөр хариуцлага дагуулахгүй гэсэн ойлголтыг нийгэмд бий болгож байна.

## 2.4 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

ИХШХШТХ-ийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх бүлгээр шүүхийн шатан дахь үр дүнтэй эвлэрүүлэн зуучлах ажиллагаа бүрдээгүй, гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэхэд мэтгэлцэх зарчим төдийгүй шүүгч нөхцөл байдлыг бүрэн шинжлэн судлах ажиллагаа, түүний зохицуулалт дутмаг байна.

### ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх илүү нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс аргачлалын өмнөх хэсгүүдэд дурьдсан асуудлууд нийгэмд үүсч байна. Иймд аргачлалд заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Зорилго:** *“Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах, гэр бүлийг хамгаалах зорилгын үүднээс шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах, эвлэрүүлэн зуучлалаар заавал орох шаардлагагүй тохиолдлыг бий болгох, шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримт цуглуулах зэрэг зохицуулалтыг бий болгох.”*

### ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 3-т заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу *“Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах, гэр бүлийг хамгаалах зорилгын үүднээс шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах, эвлэрүүлэн зуучлалаар заавал орох шаардлагагүй тохиолдлыг бий болгох, шүүгч өөрийн санаачилгаар нотлох баримт цуглуулах зэрэг зохицуулалтыг бий болгох.”* зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 2

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн	
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг.
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг	<b>Тодорхой үр дүнд хүрнэ.</b>

			бүрэн бууруулж чадахгүй .	
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Уг харилцаанд тохиромжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Уг харилцаанд тохиромжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлж болох ч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг энэ аргаар бий болгох боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	<b>Дангаараа үр дүнд хүрэхгүй.</b>
6	Захиргааны шийдвэр гаргах	Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг захиргааны шийдвэрээр бий болгох боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй .	Үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах, гэр бүлийг хамгаалах төрийн бодлого хангагдах эрх зүйн орчин бий болж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч байх хариуцлага дээшилнэ.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаануудыг цогцор нь шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	<b>Үр дүнтэй.</b>

Дээрх харьцуулалтаас харахад дараах хувилбар илүү эерэг нөлөөтэй байх магадлалтай байна.

**Хувилбар:** Хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх чухал ач холбогдолтой. ИХШХШТХ-иас тусдаа бие даасан хуулиар зохицуулах. Тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна.

Тус хуулиар *“Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслөөр гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх онцлог зарчим, журмыг бий болгох, ингэснээр хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гэр бүлийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн тогтоох, гэр бүлийн хэрэгт шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг үр дүнтэй болгохтой холбоотой харилцааг”* зохицуулна.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 4-т заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасан шалгуур асуултын дагуу тандан судалсан байдлыг хүснэгт 3,4,5,6-аас үзнэ үү.

### **5.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Боловсруулсан хувилбарын хүрээнд гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг тусдаа бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзсэн.

Өнөөдөр ИХШХШТХ-ийн дагуу гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх арга зам дутмаг байна. Тухайлбал, гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд диспозитив зарчим хэрэгжихээс гадна шүүгч нотлох зарчим хэрэгжих шаардлагатай ч ИХШХШТХ-д байхгүй. Шаардлагатай тохиолдолд шүүгч гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлуулах, байгууллага, хувь хүнээс лавлагаа, тодорхойлолт гаргуулах ажиллагааг өөрийн санаачилгаар хүүхдийн тусын тулд хийдэг байх шаардлагатай.

Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэх нь хүний эрхэд үзүүлэх эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

## 5.2 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хувьд гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангуулах эрх зүйн орчныг бүрдүүлснээр нийгэмд тулгамдаж буй олон асуудалд, тухайлбал гэрлэлт дуусгавар болсон ч хүүхдийн эрх, ашиг хөндөгдөхгүй, эцэг, эхийн хариуцлага үргэлжлэх, хүүхэд үрчилснийг хүүхдийн дээд эрх, ашиг сонирхол зөрчигдсэн эсэхийг тал бүрээс нь тогтоосны үндсэн дээр хүчингүй болгох, ингэснээр хүүхдийн эрх ашгийг хамгаалах зэрэг эерэг өөрчлөлт авчирна гэж үзлээ.

## 5.3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Тухайн харилцааг зохицуулсан бие даасан хууль батлах нь тодорхой хэмжээнд зардал гарах /тухайлбал, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч шүүхэд ажиллуулах, шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлалыг бий болгох/ боловч тухайн харилцаа нь ирээдүй хойч болсон хүүхдийн дээд эрх, ашиг сонирхол хангагдах, гэр бүл хариуцлагатай, тогтвортой байхад эерэгээр нөлөөлнө.

## 5.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Доорх хүснэгтүүдэд нарийвчилсан мэдээллүүдийг харуулъя.

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахыг хориглосон зохицуулалт байхгүй байдлаар эрх зүйн харилцааг зохицуулна.

	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулснаар нийгмийн аль нэг бүлэг, нэгж, хэсэгт давуу эрх олгохгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Бие даасан хууль батлах нь түр тусгай арга хэмжээ биш.
<b>1.2. Оролцоог хангах</b>				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэсэн шийдвэрүүд, шийдвэрийн биелэлт зэрэг бодит нөхцөл байдлыг судалсан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбар бий болсноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэд байхгүй болно.
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүүхдийн дээд эрх, ашиг сонирхол хамгаалагдах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцлага сайжирна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцсэн байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгана.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хязгаарлалт байхгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шүүх, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч, эвлэрүүлэн зуучлагч, гэр бүлийн маргаантай талууд.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хүүхэд, зарим хүндэтгэн үзэх шалтгаанаар хамгаалбал зохих нөхцөл байдалд байгаа гэрлэгч, тухайлбал хүчирхийлэлд өртсөн

				байж болзошгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаална.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шүүх нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамааран гэрлэлт цуцлалтыг шийдэхдээ хүүхдийн асуудлыг цогцоор нь судлан шийддэг байх.
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрэгтэй, эмэгтэй хүйсээр ялгаварласан зохицуулалт байхгүй.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид давуу байдал олгосон, эсхүл ачаалал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг үр нөлөө агуулаагүй. .
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.

	нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл үүсгэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зөвшөөрөл авах, тайлагнах, мэдээлэх үүргийг хуулиар ногдуулах тул тодорхой захиргааны зардал гарна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	

	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тийм нөхцөл бүрдүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хүүхдийн өмнө хүлээсэн хариуцлагыг нэмэгдүүлснээр урт хугацаандаа гэр бүлийн санхүүд эерэг үр дүнг авчирна.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн орон тооны зардал нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн тогтолцоо шүүхэд бий болно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шүүгч зөвхөн талуудын цуглуулсан нотлох баримтыг бус өөрийн санаачилгаар хүүхдийн тусын тулд нөхцөл байдлыг бүрэн дүүрэн судална.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцнэ.

### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.

	эсэх			
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шинэ стандарт бий болгохгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шинэ стандарт бий болгохгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шинэ стандарт бий болгохгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Шинэ стандарт бий болгохгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт агуулаагүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Гэр бүлийн хэргийг илүү хүүхдэд ээлтэй байдлаар шийдвэрлэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нөлөөлөл байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн бууралтад тодорхой хэмжээнд эерэгээр нөлөөлнө.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хохирогчид сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

## 5.5 Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д<sup>23</sup> “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.” гэж заасантай нийцүүлж, Монгол Улс анх удаа гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар байгуулсан бөгөөд тус шүүх үйл ажиллагаагаа 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн явуулна.

Ийнхүү шүүх байгуулахдаа Монгол Улсын шүүхийн тухай хууль 14 дүгээр зүйлийн 14.2-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу анхан болон давж заалдах шатны шүүхийг байгуулах асуудлаар Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, шүүх байгуулах асуудлаар Монгол Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжилж байсан байна.<sup>24</sup>

Дээрх Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг байгуулахдаа 2018-2022 оны байдлаарх Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн ачаалалд тулгуурласан байна.

Тодруулбал, улсын хэмжээнд иргэний 248,307 хэрэг шийдвэрлэгдсэн байх бөгөөд үүний 54% буюу 227,075 хэрэг нийслэлд, 46% буюу 195,263 хэрэг орон нутагт хянан шийдвэрлэгдсэн буюу ихэнх иргэний хэрэг нь нийслэлд шийдвэрлэгдсэн байна.

Мөн нийт 248,307 иргэний хэргээс 24,897 гэр бүлийн хэрэг шийдвэрлэгдсэн байх ба үүнээс нийслэлд 13,566 гэр бүлийн хэрэг шийдвэрлэгдсэн тул ачаалал бүхий нийслэлийн нутаг дэвсгэрийг хамруулан Гэр бүл, хүүхдийн дагнасан шүүхийг тойргийн зарчмаар байгуулах болсон байна.<sup>25</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>26</sup> Арван зургадугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” гэж заасан.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгаж, хууль, шүүхээр хамгаалдаг байх ёстой талаар тусгасан байдаг. Тодруулбал, тус конвенцын Гуравдугаар зүйлийн 1-д “Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг

<sup>23</sup> 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт.

<sup>24</sup> Шүүх байгуулах тухай хуулийн төслийн танилцуулгаас.

<sup>25</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоо мэдээлэл 2024 он.

<sup>26</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.” гэж заасан. Монгол Улс тус конвенцыг 1989 онд баталсан.

Иймд энэхүү судалгаагаар гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг тусдаа бие даасан хуулиар зохицуулах шаардлагатай гэсэн зорилгыг дэвшүүлсэн. Энэхүү зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>27</sup> Арван зургадугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.” гэсэн зохицуулалтын үзэл санаатай бүрэн нийцэх юм.

Учир нь судалгааны өмнөх хэсэгт дурдсанаар гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тус ажиллагааг илүү боловсронгуй болгох замаар дагнасан шүүхтэй тул бие даасан хууль батлах нь нийгэмд эерэг үр дагавар бий болгох юм.

Иймд тус хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой аливаа хэлбэрээр зөрчилдөөгүй болно.

## **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалд зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал
- Зардал, үр өгөөжийн харьцаа
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр дахин нягтлан үзээд дараах дүгнэлтийг хийлээ.

Захиргааны шийдвэр гаргах зохицуулалтын хувилбар нь гарах зардлын хувьд бие даасан хууль батлан гаргахаас бага зардалтай хэдий ч зорилгод хүрэх боломжгүй байна. Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар процессыг батлахыг аль нэг төрийн байгууллагад өгөөгүй тул энэ хувилбарыг хэрэгжүүлж зорилгод хүрэх боломжгүй болох нь харагдаж байна.

Харин Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь захиргааны шийдвэр гаргах зохицуулалтын хувилбараас илүү зардал гарах хэдий ч үр өгөөжийн хувьд зорилгод хүрэх боломжтой байна. Учир нь гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг процесс хуулиар зохицуулах шаардлагатай.

---

<sup>27</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

Иймд дээрх хоёр хувилбараас орчин үеийн чиг хандлага болон гадаад орнуудын зохицуулалтыг харьцуулан үзэхэд, гэр бүлийн хэргийн дагнасан шүүхтэй орнууд бие даасан хуулиар гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байх тул бие даасан хуулиар уг харилцааг зохицуулах нь илүү үр өгөөжтэй гэж үзлээ.

## **ДОЛОО. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Харьцуулсан судалгаанд олон улсын хэмжээнд илүү сайн, жишиг болохуйц туршлагаар зохицуулж буй доорх улсуудын хууль тогтоомжийг сонгон авч судаллаа.

Эдгээр улс орнууд нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах хуулиудаар зохицуулж байна.

- Бүгд Найрамдах Солонгос Улс
- Япон Улс
- ХБНГУ

БНСУ, Япон, АНУ-ын Хавай муж нь гэр бүлийн хэргийн дагнасан шүүхтэй тул уг ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж байх бөгөөд ХБНГУ нь дагнасан шүүхгүй тул Иргэний процессын хуулиараа зохицуулж байна. Энэхүү хэсэгт нийтлэг буюу жишиг зохицуулалтыг тодорхойлохыг зорилоо.

### **Бүгд Найрамдах Солонгос Улс**

Бүгд найрамдах Солонгос улс /БНСУ/-д 1963 онд Сөүл хотын гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон Улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь Family Litigation Act буюу Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуульд гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон.

Ийнхүү гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтыг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хууль /Family Litigation Act /-д тусгасан байх ба уг хуульд зохицуулаагүй харилцааг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хуулиар зохицуулдаг байдал нийтлэг ажиглагдаж байна.<sup>28</sup>

Тус хуульд гэр бүлийн хэргийн төрлийг жагсаан хуульчилсан бөгөөд мэтгэлцээнтэй /litigious/, мэтгэлцээнгүй /non-litigious/ гэж ангилдаг.

Мэтгэлцээнтэй хэргүүд, тухайлбал, гэрлэлт цуцлалт /нийт мэтгэлцээнтэй хэргийн 80 хувь нь байдаг/, сүйг цуцалсантай холбоотой гэм хор, хөрөнгө хуваах, эцэг болохыг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг. Эдгээр хэрэг нь талууд тохиролцоо хийх боломжтой хэргүүд.

Мэтгэлцээнгүй ангиллын хэрэгт, тухайлбал, сураггүй алга болсонд тооцох, овог нэр тогтоох, үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг, гэрлэлтийн

---

<sup>28</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=1081&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG)

гэрээнд өөрчлөлт оруулах, өв гэрээслэл гэх мэт. Харин эдгээр хэргүүд нь талууд тохиролцоо хийх боломжгүй хуулийн дагуу тогтоох хэргүүд юм.

Гэрлэлт цуцлалтыг шүүх шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэлэг, асрамж, уулзах хуваарь зэргийг заавал хамтад нь шийдвэрлэнэ. Гэхдээ хөрөнгө хуваах нэхэмжлэл гаргаагүй бол шийдвэрлэхгүй. Хөрөнгө хуваах бол заавал нэхэмжлэл гаргасан байхыг шаарддаг. Цуцалснаас хойш 2 жилийн дотор хөрөнгө хуваах нэхэмжлэл гаргах эрхтэй. /ИХ 839 дүгээр зүйл/

Мөн эвлэрүүлэн зуучлалаар орох хэргүүдэд гэрлэлт цуцлалт, гэм хор, тэтгэлэг тогтоох, хүүхэдтэй уулзах, хөрөнгө хуваах, эцэг эх байх эрхийг хасах зэрэг болно.

Эвлэрүүлэн зуучлалын бус хэрэгт гэрлэлт, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, сураггүй алга болсонд тооцох, овог нэр тогтоох, үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг, гэрлэлтийн гэрээнд өөрчлөлт оруулах, өв гэрээслэл гэх мэт хуулийн дагуу тогтоож шийдвэрлэдэг хэргүүд байдаг.

Эвлэрүүлэн зуучлалын хэрэг бол эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдэнэ. Шүүгч ахлаад 2 эвлэрүүлэн зуучлагчийг чиглүүлж, 2 эвлэрүүлэн зуучлагч хуралдаан хийгээд тохиролцоо хийлгэнэ. Хэрэв эвлэрбэл шүүгч баталгаажуулж, сүүлийн хуралдаан хийнэ.

Олон нийтийн дундаас 2 жилийн хугацаанд сонгон эвлэрүүлэн зуучлагч зөвхөн гэр бүлийн хэрэгт дагнан томилдог. Цалингүй. 100 гишүүнтэй. Хэрэгт орсон бол 200,000 воны урамшуулал л өгдөг. 1-2 удаа хуралдана. 1 удаа 2 цаг. 3 дахь удаа гэж бараг байхгүй. Шүүгч эхлүүлнэ, процесст орохгүй, шийдвэр гаргадаг.

Нэг нь цуцлах, нөгөө нь цуцлахгүй бол л битгий салаач гэсэн талаас хугацаа өгч, сэтгэлзүйчид хандахыг даалгадаг. Тэрнээс 20-30 жилийн өмнө 2 уулаа сална гэж ирсэн бол битгийн салаач бус асрамж, тэтгэлэг, хөрөнгийн асуудлаар тохиролцоонд хүргэхэд чиглэдэг болсон.

Бусад иргэний хэргийг шийдвэрлэхэд хууль зүйн фактыг хуулийн хүрээнд шийдвэрлэдэг бол гэр бүлийн хэрэгт энэ нь хангалтгүй, гэр бүлийн орчин, нөхцөл, маргааны шалтгаан, сэтгэлзүй гэхчилэн өөр эмзэг олон хүчин зүйлийг шалгаж байж шийддэг онцлог эрх зүй юм.

Энэ үүднээс гэр бүлийн хэргийн шүүгч нь нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн шинжлэн судлах шаардлагатай байдаг тул шүүх өөрөө нотлох, нөхцөл байдлын шинжээчийн тогтолцоо БНСУ-д байдаг байна.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь шүүхийн ажилтан, нөхцөл байдлыг хүүхдийн эрх, ашгийн үүднээс судалж, тайлан бичиж өгдөг. Шүүгч захирамж гаргаж, үүнийг даалгадаг. Нийгмийн салбарын хүн байдаг /сэтгэлзүй, социологи, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг/. 2002 онд энэ гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн систем бий болсон.

Нөхцөл байдлын шинжилгээ хийлгэх захирамж гаргах нь шүүгчийн үүрэг биш, бүрэн эрх юм. Үрчлэлтийг батлах, асран хамгаалалт харгалзан дэмжлэг тогтооход тохирох хүн эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлалтад хүүхдийг ялангуяа бага насны хүүхдийг хэний асрамжид үлдээх зэргийг тогтооход гэр бүлийн нөхцөл байдлын шинжилгээ хийгдэж байна. Уг нөхцөл байдлын шинжилгээнд гэрлэлт цуцлалтын маргааны шалтгаан нөхцөлийг тогтоож, хүүхдийн асрамжийг хэрхэн

шийдвэл зохих, талуудын эвлэрэх боломж, хүсэл, тухайн хэргийг хэрхэн шийдвэл зохих зөвлөмж боловсруулж, шүүхэд хүргүүлнэ.

Сэтгэлзүйн, хүн хоорондын харилцааны, эдийн засгийн гэхчилэн бүхий л байдлыг шалгаж болно. Тухайлбал, эрүүл мэнд бол биеийнхээс гадна сэтгэлзүй, мөн ярилцлага хийх, мөрдөх, эрүүл мэндийн материалыг эмнэлгээс шаардан авах зэрэг эрхтэй. Гэр бүлийн байдал, маргааны шалтгаан, хүүхдийн тоо, хобби, нөхөрлөл, шашин шүтлэш, гэрчийг ч асууж болно. Шинжээч талуудын жинхэнэ зорилго, санааг илрүүлэх, шалтгааныг олж тогтоох, гуравдагч этгээдийн байр суурьнаас хандах нь чухал.

Шүүгч бусад шаардлагатай байгууллагаас лавлагаа, тодорхойлолт гаргуулах, шүүх хуралдаан хаалттай явуулах, өмгөөлөгч оролцох бол зөвшөөрөл авч биечлэн оролцохгүй байх.

## **Япон Улс**

1949 онд Япон Улсад байгуулагдсан гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Personal Status Litigation Act буюу Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна.<sup>29</sup>

Бусад арилжааны шинжтэй иргэний хэрэг, насанд хүний үйлдсэн хэргийг хуулийн дагуу шийдвэрлэдэг шиг шийдвэх нь гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн хэргийг шийдвэрлэхэд хангалтгүй юм. Учир нь шүүхийн хувьд гэр бүлийн хэрэг болон насанд хүрээгүй хүний үйлдсэн хэргийг шийдвэрлэхдээ эдгээр хэргүүдийн ард орших хүний мэдрэмж, харилцаа, орчин нөхцөлийг ойлгох нь чухал юм. Иймээс гэр бүлийн шүүхэд гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн систем заавал байх шаардлага урган гарсан байдаг бөгөөд энэ нь гэр бүлийн хэргийн шүүхийн онцлог шинж болдог байна.

Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь зан суртахуун, сэтгэлзүйн чиглэлийн мэргэжилтэй байх шаардлага тавигддаг.

Энэхүү шинжээч нь дараах чиг үүрэгтэй:

- Гэр бүлийн маргаанд оролцогч талуудтай ярилцлага хийх замаар нөхцөл байдлыг судалдаг, хүүхдүүдтэй уулзаж, гэр бүлийн хэргийн талаар тэдний үзэл бодлыг сонсдог;
- Сургууль болон бусад мэдээллийн эх сурвалжууд руу очиж, мэдээлэл цуглуулдаг;
- Судалгааны үр дүнг шүүх болон оролцогч талуудад тайлагнаж, гэр бүлийн маргааныг хэрхэн шийдэж болох шийдлийг санал болгодог.

---

<sup>29</sup> <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>

- Гэр бүлийн шүүхүүд шийдвэр гаргах эрхтэй: Гэр бүлийн шүүхийн нөхцөл байдлын шинжээчийн тайлан эсвэл хүүхдийг төлөөлж буй өмгөөлөгчөөр дамжуулна.

- Хүүхдийг эцэг эхээр нь дамжуулан сонсох нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх магадлалтай тул эргэлзээтэй байж болох ч шүүхийн практикт үүнийг зөвшөөрөгдсөн байдаг.

- Японы шүүгчид хүүхдийн саналыг шууд өөрөө сонсохоос зайлсхийдэг.

- Тэд хүүхэдтэй ярилцлага хийхээр бэлтгэгдсэн.

- Тэд нээлттэй асуулт асууж, хүүхдийг эцэг эхийн аль нэгийг нөгөөтэй нь харьцуулж сонгохыг албаддаггүй.

- Тэд хүүхдийн ярилцлагын үр дүнг шүүх болон эцэг эхтэй хуваалцдаг.

Гэр бүлийн шүүхийн харьяалалд олон төрлийн гэр бүлийн хэрэг хамаардаг. Үүнд, тухайлбал: гэрлэлт цуцлалт, эцэг эх байх эрхийн асуудал, хүүхдийн асрамж, хүүхдийн үрчлэлт, эцэг тогтоох, хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох, өв хөрөнгийн хуваарилалт гэх мэт.

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах төрөл байна. Үүнд:

### **1. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлал**

Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх хэргүүд байна. Жишээ нь: хүүхдийн асрамж, өвийн эд хөрөнгийн хуваарилалт гэх мэт. Хэрэв эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон тохиолдолд хэргийг автоматаар шүүхэд шилжүүлнэ.

### **2. Гэр бүлийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ дан ганц хууль зүйн фактад бус маргааны шалтган нөхцөлийг тал бүрээс нь судалж, дүгнэсний үндсэн дээр шийдвэрээ гаргадаг. Зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар ордог хэрэг байна. Үүнд, жишээ нь: эцэг эхийн эрхийг хасах, асран хамгаалагч томилох гэх мэт.

### **3. Хувийн байдалтай холбоотой маргаан**

Жишээ нь: гэрлэлт цуцлалт. Шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө заавал эвлэрүүлэн зуучлалаар орох ёстой. Гэрлэлт цуцлах нэхэмжлэлийн хувьд эцэг, эх хүүхдийн асрамжийн асуудал, хүүхэдтэй уулзалт тогтоох, хүүхдийн тэтгэмж төлөх зэрэг асуудлаар тохиролцож болно. Хэрэв тэд тохиролцож чадахгүй бол шүүх хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах уулзалт тогтоох, хүүхдийн тэтгэлэг гэх мэт асуудлыг нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр шийддэг.

Эвлэрүүлэн зуучлах хороог хэрэг бүрд тухайлан байгуулдаг. Энэ нь гэр бүлийн шүүхийн шүүгч болон нэг эрэгтэй, нэг эмэгтэй хоёр эвлэрүүлэн зуучлагчаас бүрдэнэ. Эвлэрүүлэн зуучлагчид нь тодорхой хэмжээний нөхөн олговор авдаг, энэ нь өндөр биш сайн дурын ажилтнуудын цалин хөлс шиг хэмжээний байдаг,

шүүхийн үндсэн ажилтан биш. Тэд 40-70 насныхан байх ёстой бөгөөд тэдний 70% нь 60-аас дээш насныхан байна 90% нь эвлэрүүлэн зуучлалын мэргэжлийн бус, тухайн орон нутгийн иргэд байдаг.

Эвлэрүүлэн зуучлах хуралдаанууд:

- Нэг удаагийн биш; ихэвчлэн 5-6 удаагийн уулзалт шаардлагатай.
- Сард нэг удаа зохион байгуулагддаг бөгөөд дунджаар 7 сар үргэлжилдэг.
- Эвлэрүүлэн зуучлагч нар хуралдаанд байнга оролцдог, харин шүүгчид хуралдаан бүрд оролцдоггүй, зөвхөн эвлэрүүлэн зуучлагчдад зааварчилгаа өгдөг.
- Нэг талтай нь цаг тухайд нь уулзаж, дараа нь нөгөө талтай уулзаж болно.
- Эвлэрүүлэн зуучлах гэрээ нь шүүхийн эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэртэй адил адил үр дүнтэй байдаг.
- 2022 онд гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 46.3% нь тохиролцоонд хүрч, 19.8% нь тохиролцоогүй, 17.5% нь өргөдлөө буцаажээ.

## **НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **Зөвлөмж**

Гэр бүлийн дагнасан шүүхтэй улсуудад гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх онцлогийг тусгасан бие даасан хуультай байна.

Учир нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх нь шүүгчээс тухайн хэргийн учир шалтгаан, нөхцөл байдал, мэдрэмж, харилцаа гээд олон нөхцөлийг шалгах, дүгнэх, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор ирээдүйг нь бодсон шийдвэр гаргах шаардлага үүсдэг онцлог ажиллагаа тул энэхүү онцлогийг харгалзан үзэж, одоогийн ИХШХШТХ-д заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэх бүлгийг боловсронгуй болгосноор Монгол Улс гэр бүл, хүүхдийн дагнасан шүүхтэй болсны, мөн олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улсын сайн туршлагад энэ чиглэлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нийцүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан нийтлэг буюу жишиг зохицуулалтыг тодорхойлсны үндсэн дээр Монгол Улсын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар дараах дүгнэлтийг өгч байна.

1/Дагнасан шүүхтэй улсад гэр бүлийн хэргийг шийдвэрлэх онцлогийг тусгасан бие даасан процесс хуультай байх тул Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай бие даасан хуулийн төсөл боловсруулж, онцлогийг тусгах;

2/Харин бие даасан хуульд тусгагдаагүй нийтлэг журмын хувьд ИХШХШТХ-ийг хэрэглэх;

3/Гэр бүлийн хэргийг шийдвэрлэхэд зөвхөн талуудын нотлох баримт бус шүүгч идэвхтэй байх, өөрийн санаачилгаар шалгах ажиллагаа явуулдаг байх;

4/Гэр бүлийн хэргийг шийдвэрлэхэд бусад хэргийг шийдвэрлэхээс ялгаатай буюу гэр бүлийн орчин, нөхцөл, харилцаа, мэдрэмж гэхчилэн уг маргааны шалтгаан нөхцөлийг тогтоох, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангах үүднээс

ирээдүйг бодсон шийдвэр гаргах шаардлагатай байдаг тул шүүхэд гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах шинжээч заавал байх нийтлэг зохицуулалт байх тул энэхүү тогтолцоо, зохицуулалтыг бий болгох;

5/Шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай сургалтад жил бүр хамруулдаг байх;

6/Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчээр дамжуулан хүүхдээс санал авах, тус шинжээч гэр бүлээс ярилцлага авах, шаардлагатай баримт, мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлыг очиж судлах зэрэг эрхийг хуульчлах;

7/Шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлах хороог бий болгож, шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлалыг үр нөлөөтэй болгох;

8/Эвлэрүүлэн зуучлалаар ганцаарчлан уулзах, зөвөлгөө өгөх, сэтгэлзүйчтэй уулзуулах зэргээр гэрлэлт цуцлахгүй байх талаас зөвлөхөөс гадна хэрэв талууд үнэхээр гэрлэлтээ цуцлахаар бол хүүхдийн асрамж, тэтгэлэг, тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах уулзалтыг тогтоох, хөрөнгө хуваах асуудлаар тохиролцож болохоор хуульчлах;

9/Гэр бүлийн хүчирхийллээс гадна тусдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн зэрэг хүндэтгэн үзэх шаардлагатай, эвлэрэх боломжгүй нөхцөлийг бий болгож, эвлэрүүлэн зуучлалд заавал хамрагдах шаардлагаас чөлөөлөх.

## **ЭХ СУРВАЛЖ**

### **Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хууль тогтоомжийн тухай хууль
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. Гэр бүлийн тухай хууль
5. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль
6. Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль
7. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль
8. Монгол Улсын шүүхийн тухай хууль
9. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
10. Хүүхдийн эрхийн конвенц
11. Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг
12. Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 68 дугаар тогтоол

### **Ном, судалгаа шинжилгээний бүтээл**

Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

### **Гадаад эх сурвалж**

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4178/en>  
[https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=1081&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=1081&lang=ENG)

**Цахим эх сурвалж**

Shuukh.mn